

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
“ХҮДРЭНТ” ХХК

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН
НУТАГТ ОРШИХ “ХОНГОР -3” ЖОНШНЫ ОРДЫГ
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот
2025 он

Батлав: БОУАӨЯ-ны ХБОБХГ-ын дарга

.....Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Хүдрэнт”ХХК-ний захиралБ.Мөнхбат



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ

“ХОНГОР -3” ЖОНШНЫ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН

2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017256)

(Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2732521)

Хянасан: БОАЖЯ-ны ХБОБХГ-ын мэргэжилтэн

.....

Боловсруулсан:

“Хүдрэнт” ХХК –ийн геологич, байгаль орчны мэргэжилтэн

..... Б.Батбаяр

Улаанбаатар

2025 он

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	2
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	10
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13
4.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	14
4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	16
4.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	16
4.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
4.10 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	19

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төсөл хэрэгжүүлэгч: “Хүдрэнт” ХХК

Улсын бүргэлийн дугаар: 9011054065

Регистрийн дугаар: 2732521


Төслийн нэр: Хайлуур жоншны орд ашиглах

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар, 6-р хороо, метро бизнес төв. Утас: 99006331 .

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: “Хүдрэнт” ХХК-д АМГТХЭГ -ын 2013 оны 01-р сарын 30 -ны өдрийн шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хонгор-3 нэртэй газарт ашигт малтмал ашиглах MV-017256 дугаартай тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон.

Ордын нөөцийн баталгаажуулалт: ЭБМЗ-ийн 2012 оны 1-р сарын 11-ний өдрийн ХХ01-04 тоот дүгнэлт, АМГ-ын даргын 2012 оны 1-р сарын 23-ны өдрийн 46 тоот тушаалаар В+С зэрэглэлээр батлагдсан 192872 т хүдэр, 73396.1 т хайлуур жоншны нөөцийг хүлээн авсан.

Төслийн хэрэгжих байршил: MV-017256 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Хонгор-3”-ийн жоншны ордын талбай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт оршино. Улаанбаатар хотоос зүүн урагш 330км, Сайншанд хотоос баруун урагш 130 км, Даланжаргалан сумын төвөөс урагш 20 км, төмөр замын Айраг өртөөнөөс баруун тийш 28 км зайд 24.93 га талбайг эзлэн оршино.



Зураг 1. MV-010927 тусгай зөвшөөрөлтэй талбайн байршил

Ордыг ашиглах арга

Хонгор-3 ордын боломжтой В зэрэглэлээр тогтоогдсон 1-В-1, 2-В-2 блокын нөөцийг олборлох техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгав. Хүдрийн биетүүд нь 70-72° уналтай, 3.45-5.57 м зузаантай, 63-65 м гүнд тогтоогдсон байна. Захиалагч компаний техникийн даалгаврыг үндэслэн тус ордыг ил ба далд хосолсон аргаар ашиглахаар тусгалаа.

А) Илх ауйун ашиглалтын системийн сонголт

Хонгор-3 хайлуур жоншны ордын ил аргаар ашиглах нөөцийн хэмжээ, уурхайн ашиглалтын хэтийн төлөв, ашиглалтын технологи зэргийг үндэслэн **авто тээвэртэй, гадаад овоолготой** ашиглалтын систем хэрэглэхээр төсөлд тусгав.

Б) л дД ау у р х а й н ашиглалтын системийн сонголт

Ордын VII хүдрийн биет нь дунджаар 70-72° уналтай, нөөц тогтоосон гүн нь 60 м, хүдрийн дундаж зузаан нь 3.45-5.57 м байна. Геолог-хайгуулын ажлаар тодорхойлогдсон хүдрийн биетийн үндсэн үзүүлэлтүүдийг үндэслэн **дэд давхарын штрекээр нураах ашиглалтын систем** ашиглалтын системийг сонгох нь хамгийн тохиромжтой байна.

Ордын нөөц:

2020 оны 01 -р сарын 01 -ний байдлаар ордын хэмжээнд боломжтой В зэрэглэлээр 79492 т хүдэр, 32453.0 т хайлуур жонш, С зэрэглэлээр 97670 т хүдэр, 37647.9 т хайлуур жонш, нийт В+С зэрэглэлээр 177162 т хүдэр, 70099.9 т хайлуур жоншны нөөц байна.

Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

а) Ил уурхай

Ил уурхайн календарьчилсан төлөвлөлтийн байдлыг уулын ажлын эцсийн байдлын хүрээнд хийгдсэн тооцоо, зургуудыг үндэслэн хийв. Ил уурхайн хүрээ хязгаар дахь нөөцийг ашиглалтын эхний жилд олборлож дуусах бөгөөд сард 6737.7-8354.8 мян.м³ хөрс хуулалт, 2855-3540 т хүдэр олборлолтын ажил хийгдэх ба хөрс хуулалтын дундаж коэффициент 2.36 м³/т байна.

Хүснэгт 1. Ил уурхайн уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Улирлууд				Нийт
		I	II	III	IV	
Хөрс хуулалт	м³	24058.2	22908.2	22638.7	22027.7	91632.8
Хүдэр олборлолт	т	10107	9707	9593	9421	38827
Хөрс хуулалтын коэф	м³/т	2.38	2.36	2.36	2.34	2.36

б) Далд уурхай

“Гипроруда” хүрээлэнгийн бололвсруулсан СН-440-79-60 аргачлалаар уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг зохиоход малталт нэвтрэлтийн хамгийн бага хурдыг баримтална. Малталтын хөндлөн огтлолын талбайн хэмжээнээс хамаарах нэвтрэлтийн хурдны хамгийн бага үзүүлэлтийг хүсн.№ II.10-т үзүүлэв. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг боловсруулахад дараах нөхцлүүдийг баримтлав.

Хүснэгт 2. Уулын малталт нэвтрэлтийн хурд (СН-440-79-60 нормоор)

Уулын малталт, хийгдэх ажлын төрөл	Хэмжих нэгж	Хамгийн бага хурд	
		СН-440-79-60 нормоор	Төслийн
Гол ам: - босоо	м/сар	30-35	30
Квершлаг	м/сар	60 хүртэл	30
Хээрийн штрэк	м/сар	50, 65-80	60
Восстающий	м/сар	31-40, 45	1.5
Гол ам орчмын малталтууд, уулзварууд	м³/сар	350	287
Гол амны тоноглоогоо	м/сар	250	
Гол амны бэхэлгээ	м/сар	180-230	

Уурхайн үндсэн тоног төхөөрөмж болон туслах тоног төхөөрөмж

Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмж:

Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

- 1.2м³ утгуурын багтаамжтай Hyundai Robex-3700 маркийн шууд утгуурт экскаватор
- 25 т даацтай HOWO маркийн автосамосвал
- 3 м³ шанаганы багтаамжтай XCMG маркийн утгуурт ачигч
- Үйлчилгээний машин зэрэг болно.

Далд уурхайн нэвтрэлт ба цэвэрлэгээний ажлын үндсэн ба туслах тоног төхөөрөмж

Далд уурхайн дотоод тээврийг 0.8 м³-ийн тэвшний багтаамжтай KFU-0.8 маркийн тэргэнцэрээр гүйцэтгэнэ. Z-17AW маркийн утгуурт ачигчаар ачилтыг явуулах ба уулын цулыг СТУ-8/6G маркийн цахилгаан зүтгүүрээр мөрөгцгөөс дунджаар 140-150 м зайд гол амны хашаа хүртэл тээвэрлэж босоо гол амны өргөх төхөөрөмжийн тусламжтай газрын гадаргууд татаж гаргана.

Дэд бүтэц

Уурхайн барилга байгууламж төлөвлөлт

р г х ж с э г

Босоо гол босоо ам нь дугуй хэлбэрийн 3.2 м диаметр бүхий хөндлөн огтлолын талбайтай бөгөөд хоосон чулуулаг, тоног төхөөрөмж, материал зөөх зориулалттайгаас гадна хүн явах хэсгээр тоноглогдсон байна. Босоо гол амыг өргүүрээр тоноглож чиглүүлэгчийн үүргийг ган рельс гүйцэтгэнэ.

Хүснэгт 3. Өргөх хэсгийн тооцооны үндсэн үзүүлэлтүүд

Ажлын горим	340 хон/жил, 3 ээлж/хон, ээлж – 7 цаг
1 жилд гаргах хоосон чулуулгийн хамгийн их хэмжээ	м³
	т
1 жилд гаргах хүдрийн хамгийн их хэмжээ	м³
	т
Хоосон чулуулгийн хэмжээ, т/хон	

Хүдрийн хэмжээ, т/хон	234÷246
Чулуулгийн сийрэгжилтийн коэффициент	1.25~1.45
Сийрэгжсэн чулуулгийн жин, т/м ³ : - хоосон чулуулаг	1.94~2.25
- хүдэр	1.88
Хүний нөөцийн хамгийн их ачаалал, хүн/ээлж	
Хамгийн их ачаалалтай календар хугацаа, сар	2 дахь жилийн 4-р сар
Хамгийн өндөр ачаалалтай үед гаргах тэргэнцэрийн тоо, ш: үүнээс: - хүдэр ачсан тэргэнцэрийн тоо - хоосон чулуулаг ачсан тэргэнцэрийн тоо	
Өргөх хамгийн их өндөр, м	64

Засварын газар:

Уурхайн засвар техникийн үйлчилгээний дэд бүтэц зориулалт, ажлын хэмжээний дагуу уулын ажлын механик тоног төхөөрөмжийн засварын хэсэг, авто засвар техникийн үйлчилгээний хэсэг, цахилгаан тоноглолын засварын хэсэг, түлшний резервуар, түгээх хэсэг, материал, сэлбэгийн агуулах зэргээс бүрдэнэ. Байрны хэмжээ 15 м×20 м эсвэл 20 м×25 м харьцаатай болно.

Ус хангамж:

Төсөлд шаардлагатай усны эх үүсвэрийг өөрийн эзэмшлийн 108°58'45.4" Е, 45°48'02.63"N байршилтай 5.8 л/с (501.1 м³/х) –ийн ундрагатай худгаас хангана.

Цахилгаан хангамж:

Одоо ашиглагдаж байгаа 30 кВт чадалтай дизель цахилгаан станцыг тосгоны хэрэгцээнд цаашид ашиглана.

Уурхайн авто зам:

Дотоод тээвэр:

Ажлын н Ил уурхайгаас олборлох хүдрийн хэмжээ 38.8 мян.т, ил уурхайн хөрс хуулалтын ажлаар тээвэрлэх хоосон чулуулгийн хэмжээ нийт 91.6 мян.м³ байна. Уурхайн тээвэр нь гадаад ба дотоод гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Уурхайн дотоод тээвэрээр гүйцэтгэх шаардлагатай ажлуудын төрөл, хэмжээ:

1. **Маршрут №1: Ил уурхай → хөрсний овоолго.** Энэ нь хөрс хуулалтын ажлын үндсэн хэсэгт багтах ба ашиглалтын нийт хугацаанд 91.6 мян. м³ хөрс хуулах бөгөөд дунджаар 0.5 км зайд тээвэрлэнэ.
2. **Маршрут №2: Ил уурхай → ялгах цех.** Ил уурхайгаас олборлосон хүдрийг ялгах цехийн хүдэр хүлээн авах бункерын ойролцоо байгуулах түр агуулахад хураана. Тээврийн дундаж зай нь 0.5 км байна.

Гадаад тээвэр:

Тусгай зөвшөөрөлтэй талбайгаас олборлосон жоншийг Айраг өртөөний ачилт, буулгалтын талбай хүртэл 26.5 км зайд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэнэ.

2.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уур амьсгал

Дорноговь аймгийн уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй. Судалгаа явуулсан бүс нутаг буюу Даланжаргалан сумд цаг уурын харуул хараахан тавигдаагүй байгаа бөгөөд тус сум Айраг сумтай ойрхон хиллэдэг учир цаг уурын мэдээг Айраг сумаар төлөөлүүлэн авсан. Энэ бүс нутагт 6,7,8-р саруудад харьцангуй дулаан, 12,1,2-р саруудад харьцангуй хүйтэн байдаг нь харагдаж байна. Айраг сумын хэмжээнд хүйтний улиралд харьцангуй бага хур тунадас унадаг ба дулааны улиралд жилийн нийлбэр хур тунадасны ихэнх хувь ордог байна. Тухайлбал, Хур тунадас 5-10 дугаар сард хамгийн их орох бөгөөд 6-7 дугаар сараар авч үзэхэд жилийн нийлбэр хур тунадасны 53 орчим хувь унадаг. Салхиын хамгийн их хурд 15-20 м/с хүрсэн байна.

Газар ашиглалтын өнөөгийн байдал

Байгаль орчны төлөв байдлын хээрийн судалгааны үед уурхайн 11.3 га талбай уурхайн жонш олборлолтын үйл ажиллагаанд өртөж эвдрэлд орсон байсан байна. Уурхайн эвдрэлд орсон талбайд овоолго, далан, уурхайн дотоод зам зэрэг байв. Уурхайн кемп болон тэсрэх бодисын агуулахын талбай, зорчих хэсгийн зам зэрэг нь эвдрэлд бага өртсөн байна. Бусад хоосон орон зайд хөрсний эвдрэл, бохирдол байхгүй байгалийн өнгө аясаар байна.

Геологийн тогтоцын төлөв байдлын товч тодорхойлолт

Дүүргийн геологийн тогтоцын тухай орчин үеийн ойлголт сүүлийн жилүүдэд Хонгорын хайлуур жоншны ордын дүүрэгт хийсэн 1:50000-ын масштабын геологийн зураглалын ажлын үр дүнд тулгуурласан байдаг (Г.Ёндон, Л.Баадай нар 1982 он). БНМАУ-ын структур-тектоникийн дүүрэгжилтээр (Р.А. Хасин, 1966 он) уг дүүрэг нь Дорнод Монголын геоантиклиналь бүсэд оршино.

Дүүргийн геологийн тогтоцод дээд Протерозойн (РК.3), дээд Девон-доод Карбоны Эз-СО дунд-дээд Карбоны (C₂-з), доод Цэрдийн (K0, дунд-дээд, орчин үеийн Дөрөвдөгчийн (Рц.ш, С^у) насны хуримтлал, хожуу Палеозойн ба Мезозойн гүний чулуулаг чамаарагдана.Хонгорын хайлуур жоншны ордын районд дээд Протерозойн тунамал хувирмал давхаргадас, Мезозойн тунамал болон бялхмал чулуулаг, Кайнозойн сэвсгэр хурдас зонхилох ба харьцангуй багаар Девон, Пермийн боржингийн биет тархсан болно.

Гүний усны төлөв байдлын тодорхойлолт

Судалгааны талбай нь Монгол орны гидрогеологийн дүүрэгчлэлээр Хангай – Хэнтийн уулархаг мужийн хөрсөн доорхи ус зонхилон тархсан бүсэд хамаарагддаг. Дүүргийн гидрогеологийн нөхцөл, давхарга зүйн ангилал тус бүрийн литлогийн онцлог, шүүрэлтийн шинж чанар, судалгааны түвшин зэргээс шалтгаалан дүүргийн хэмжээнд дараах ус агуулсан давхаргууд болон комплексууд ялгагдсан байна.

Үүнд:

- а.Дөрөвдөгчийн хурдасны ус агуулсан горизонт (Q_{IV})
- б.Протерозойн карбонатлаг хурдасны ус агуулсан комплекс/PRз/
- в.Пермийн вулканоген-тунамал чулуулгийн ус агуулсан комплекс / P /
- г.Мезозой-Палеозойн насны гүний чулуулгийн газрын доорхи ус /Mz-PZ/

Ургамлан нөмрөг

Дорноговийн Даланжаргалан сумын нутагт олборлолт хийж буй Хонгор-3 жоншны талбай, түүний орчмоор 14 овогт хамаарах 30 төрлийн 45 зүйл цоргот дээд ургамал тархаж байна. Хамрах ургамлын зүйлийн тоогоороо дараах овгууд тэргүүлж байна. Үүнд: Биелэгтэн (*Poaceae*) 8 төрөл 11 зүйл, Голгэсэртэн (*Asteraceae*) 3/8, Луультан (*Chenopodiaceae*) 5/6, Саргайтан (*Liliaceae*) 2/4, Баширтан (*Caryophyllaceae*) 2/3, Саргайтан (*Rosaceae*) 2/3 байна.

Амьтны аймгийн төлөв байдал

Амьтны шинжээч Даланжаргалан сумын нутагт амьтны аймгийн судалгааны төсөлт ажил 4-ийг гүйцэтгэсэн тул өөрийн эдгээр судалгааны материал, үр дүн, амьтан судлаачдын бүтээлд (Ашигласан бүтээлийн жагсаалт) тэмдэглэсэн зүйлүүд болон ам мэдээг нэгтгэн тус нутагт 206 зүйл шавж, 3 зүйл мөлхөгч, 27 зүйл шувуу, 16 зүйл хөхтөн амьтан бүртгэсэн байна.

Азийн улаан номонд орсон 1 зүйл, ховор болон ховордсон амьтан, ургамлыг олон улсын хэмжээнд худалдаалах конвенц – CITES-ийн II хавсралтанд орсон 7 зүйл шувуу байна. Хамгаалагдсан шувуудаас 5 зүйл нь суурин амьдарна.

Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хавсралтанд саарал чоно, шар үнэг, хярс, мануул орсон ба мөн мануул Монгол улсын хөхтөн амьтны улаан данс ба IUCN Red List-д ховордож болзошгүй, цагаан зээр Монгол улсын хөхтөн амьтны улаан дансанд устаж болзошгүй гэсэн статустай бүртгэгдсэн.

3.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт

Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлтийг 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтоц шууд нөлөөлөлд богино хугацааны дундаас хүчтэй нөлөө үзүүлэхээр байгаа бол гүний усны нөөц, чанар, горимд богино хугацааны дунд нөлөөлөл үзүүлэх бол зэрлэг ан амьтдын орон зайн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлтөн өөрөө зохицуулагдах богино хугацааны бага- дунд нөлөө үзүүлэхээр байна.

Ил/далд уурхайн үйл ажиллагаанд технологид ус ашиглахгүй ба газрын гүнд олборлолт хийх нь геологийн тогтоцод хүчтэй нөлөөлөх үндэс болж байна, мөн хүдрийн овоолго болон ачилт тээвэрлэлтийн үйл ажиллагаагаар хөрсөн бүрхэвч (говийн маш эмзэг хөрсөн бүрхэвч) хүчтэй элэгдэл эвдрэлд өртөхөөр байна.

Байгалийн нөөцийн ашиглалт

Байгалийн нөөцийн ашиглалтыг 4 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд газрын доорх нөөц баялаг, бэлчээр тэжээлийн ургамлын нөөц баялаг, эрчим хүчний нөөцөд богино хугацааны дундаас-хүчтэй нөлөө үзүүлэхээр байгаа бол эрдэс түүхий эдийн нөөцөд өөрөө зохицуулагдах бага эрчимтэй нөлөөллөхөөр байна.

Байгалийн баялгийг олборлож эдийн засгийн эргэлтэнт оруулж байгаа бөгөөд энэ нь дахин нөхөн сэргээгдэхгүй, мөн уурхайн дагалдах байгууламжийн нөлөөгөөр хязгаарлагдмал орчны ургамлан нөмрөг үгүй болно. Уурхайн үйл ажиллагаанд цахилгаан ашиглах тул эрчим хүчний нөөцөд шууд богино хугацааны дунд эрчимтэй нөлөөлхөөр байна.

Байгаль орчны өөрчлөлт

Байгаль орчны өөрчлөлтийг 4 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд өөрөө зохицуулагдах богино хугацааны бага-дунд нөлөө үзүүлэхээр байна.

Уурхайн үйл ажиллагааны үед машин механизмийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх болон техник хэрэгслийн дуут дохио, хөдөлгөөний эрчмээр дуу шуугиан ихсэх бол хог хаягдлыг зөв зохицуулаагүйгээс хөрсний эрүүл ахуйн болонн хүнд металлын бохирдол үүсэх эрсдэлтэй. Тиймээс ахуйн бохир усыг зөв зохицуулах, хог хаягдлыг тогтмол хугацаанд тээвэрлүүлэн хог хаягдлын цэгт нийлүүлэх, техникийн засвар үйлчилгээний газрыг хатуу хучилттай болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Нийгэмд үзүүлэх нөлөө

Нийгэмд үзүүлэх нөлөөллийг 3 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд шууд богино хугацааны эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Төслийн үйл ажиллагаагаар орон нутгийн хөрөнгө оруулалт ихсэж дэд бүтцийн хөгжил, хүн амын орлого нэмэгдэх зэрэг эерэг нөлөөлөл бага хэмжээгээр бий болох боломжтой.

Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор

Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх байдлыг 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх, ландшафтын төрх өөрчлөгдөх зэрэгт шууд бус богиноос урт хугацааны дунд-хүчтэй нөлөө үзүүлэхээр байгаа бол тусгай хамгаалалттай ба цогцолбор газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор зэрэгт өөрөө зохицуулагдах нөлөө үзүүлэхээр байна.

Эдийн засаг

Эдийн засагт үзүүлэх нөлөөллийг 4 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 4 үүлээ богино хугацааны эерэг нөлөө бага-дунд эрчимтэй нөлөөлхөөр байна.

Эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэдэг нь орон нутаг болон улсын төсөвт хөрөнгө оруулалт хийх, шинэ ажлын байр бий болгох, сумын хөгжилд хөрөнгө оруулалт оруулах арга хэмжээнүүд орно.

Бусад нөлөөлөл

Бусад нөлөөллийг 4 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд богино хугацааны шууд бага-дунд нөлөө үзүүлэхээр байна. Үүнд: шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих, машин техникийн нөлөөгөөр тоосжилт орон зайд тархах зэрэг шууд нөлөөллүүд бий болохоор байна.

Нөлөөллийн хэлбэр

Уурхайн технологийн үйл ажиллагаагаар шууд нөлөөлөл 14 үүнээс 8 сөрөг, 6 эерэг нөлөөлөл байгаа бол шууд бус нөлөөлөл 3, өөрөө зохицуулагдах 12 байна үүнээс үзэхэд шууд нөлөөлөл ихтэй төсөл байна.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Төсөл нь 3-4 жил олборлолт хийх ба байгаль орчны бүрдэл хэсэгт богино хугацааны 17 сөрөг нөлөөлөл 6 эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна. Урт хугацаанд геологийн тогтоц болон ландшафтын төрхөд хүчтэй нөлөө үзүүлэхээр байна.

Нөлөөллийн эрчим

Төслийн үйл ажиллагаанаас геологийн тогтоцын өөрчлөлт, газрын доорх нөөц баялаг, тоосжилт ихсэх, ландшафтын төрх өөрчлөгдөх зэрэг 4 хүчин зүйлд хүчтэй нөлөөлөх бол бага нөлөөлөл 15, дунд нөлөөлөл 7 байна.

4.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2014 онд Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах

Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах

Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах

Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх

Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР						
Тоосжилт үүсэх	Дотоод тээврийн 1 км зам болон гадаад тээврийн 26.5 км замын арьчилгааг тогтмол хийх	Эвдрэл гарсан тухай бүр засварлах буюу хонхор гүдгэрийг тэгшлэх, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Эвдрэл үүссэн тухай бүр засч байх	Өөрийн техник хэрэгслээр үйл ажиллагааны зардлаар		“Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын дагуу барих Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль; Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008 Бензин хөдөлгүүртэй авто машин- Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Дизель хөдөлгүүртэй авто машин- Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
Утаа болон хийн бохирдол үүсэх	Машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, шаардлагатай тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх төхөөрөмж тавих	Гэмтэл гарсан тухай бүрт	2025 онд	Сэлбэг материалын зардалд тусгагдсан		
	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Хүнд даацын машин механизм болон суудлын машин техник		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ						
Хөрсний элэгдэл,	Дотоод зам тавих, маршрут чиглэллийг заасан тэмдэглэгээ хийх	Тогтмол хяналт тавьж, эвдрэл гарсан тухай бүрт засварлах	2025 оны I улиралд	-	0.3	Газрын тухай хуулийн 50-р зүйл 50.1.1 дэх заалт.

эвдрэл бий болох	Уурхайн талбайд тарьсан 50 ш улиас болон үрсэлгээний 200ш улиасыг арьчлах	Тарьсан улиас модыг усалж тордох,ургах нөхцлийг бүрдүүлэх, ойр орчим техник зорчуулахгүй байх хаалт хийх, мал амьтан нахиаг идхээс хашаалж хамгаалах, ургалтыг хянах	2025 оны дулааны улиралд услах 7 хоногт 1	0.2	MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
Хөрсний үржил шим алдагдах	хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Төслийн хугацаанд 107.2 мян.м³ хөрс хуулж овоолго үүснэ.	2025 онд	Үйл ажиллагааны зардалд орсон	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”
	Уурхайн үйл ажиллагаанд өртсөн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	Нөлөөлөлд өртөх 12.3 га талбай	2025 онд	Нөхөн сэргээлтийн зардалд орсон	
3. ГҮНИЙ УС					
Усны нөөц багасах, түвшин буурах	Гүний усны нөөц, түвшин зэргийг компанийн үйл ажиллагаатай уялдуулан судалгаа хийх	Төслийн талбайн ойролцоох малчдын худагт жилд 1 удаа гүний усны түвшин, ундрага хэмжих	2025 оны 6 сард	0.5	Монгол Улсын стандарт (MNS 4943-2011), Дэлхийн банкны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай. Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. ”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
4. АМЬТНЫ АЙМАГ					
Идэш тэжээлийн хомсдол үүсэх	Биотехникийн арга хэмжээ авч ажиллах	Уурхай орчимд өвөлждөг амьтдад биотехникийн арга хэмжээ авч ажиллах байгаль хамгаалагчтай хамтран ажиллах тоо толгойг бүртгэх	2025 оны өвөл (11, 12 сард)	-	0.5 Амьтны тухай хууль: 6.1.3.амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах;

Амьдрах орчин хумигдах, гүйдэл шилжилт хөдөлгөөнд саад бий болох	Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах, нүүдэл шилжилт хөдөлгөөнд саад болохгүй байхаар аюулгүй байдлыг хангах	Уурхайн талбайд төлөвлөлтийн бусаар эвдэрсэн газар буюу ухаш, овоолгыг тэгшилж мал амьтанд аюулгүй болгох	Эвдрэлд орсон талбайн бүртгэд хөтөлж нөхөн сэргээх	Үйл ажиллагааны зардлаар	6.1.7.үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх; 6.1.8.биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
2025 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал				1.5	

4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлт зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт нь эвдрэлд орсон ухаш буюу хоосон орон зайг нөхөн дүүргэж хүн амьтанд аюулгүй байдлыг бий болгох зорилготой	0.8 га газрын 0.1га-д нөхөн дүүргэлт хийж ухаш буюу хоосон орон зайг 0.7 га дах овоолгоор нөхөн дүүргэж тэгшлэх	0.8 га	2500 м ³	22095ц/т	1590.	2025 оны намар	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал 2015 оны 03 сарын 30 өдрийн А-138

4.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн барим бичиг
1	Төслийн үйл ажиллагаанд өртсөн байгалийн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг экосистемийн ижил орчинд нөхөн хамгаалах.	Биотехникийн арга хэмжээ Төсөл хэрэгжих суманд сөөг сөөгөнцөр тарих	Цаг үеийн эрсдэлд зэрлэг амьтад биотехникийн аргаар хооллох бололцоог хангах зорилгоор хужир, өвсийг байршил бүхий онцгой бүс, амьтдын гол тархац бүхий газруудыг сонгон биотехникийн ажил хийх.	-	-	1500.0	2025 оны өвөл	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.6-д заасанчлан байна.

4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хонгор-3 жоншны ордыг ашиглах явцад нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний ажил хийгдэхгүй.

4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай, түүний орчимд хамгаалах шаардлагатай түүх, соёлын дурсгалт зүйлс бүртгэгдээгүй байх ба уурхайн ашиглалтын үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг авран хамгаалах ажлыг зохион байгуулна.

4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал сая.төг	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Галын аюулгүй байдал					
1	Түлшний агуулах, автомашин, ажилчдын	Гал түймрээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл (галын дохиолол,) болон гал гарсан тохиолдолд унтраах, хамгаалалтын багаж хэрэгслийг	2025	0.3	Галын аюулгүй байдлын тухай: Зүйл 16-1, 2; Зүйл 18-1, 2;

Дорноговь аймаг Даланжаргалан сумын нутагт орших “Хонгор-3” жоншны ордыг ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болозошгүй	шаардлагатай газруудад байрлуулах, байрлуулсныг арчлан хамгаалах шаардлагатай зүйлсийг сэлбэх			Зүйл 19-1, 2; Зүйл 20-1, 2; Зүйл 21-1, 2, 3 Галын аюултай бодис. Материал ангилал. MNS 4284:95
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж цайны газар, ажилчдын тахины цэг болон бусад шаардлагатай гэсэн газарт барлуулах, байрлуулсныг хамгаалах		0.2	
		шатах тослох материалын хадгалалт хамгаалалтыг стандартын дагуу хийж түүнтэй харьцан ажиллах ажилчдыг мэргэжлийн сургалтанд тогтмол хамруулах		0.5	
Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл					
2	Хүчтэй салхи, шороон шуурганы үед харагдах орчин хязгаарлагдах ажил зогсох	Уурхайн ажилыг түр зогсоох, машин техникийг аюулгүй байдал хангасан газар зогсоож, уурхайн нурулт, гулсалтаас сэргийлэх арга хэмжээ авах, ажилчдад аюулгүй байдлын зааварчилгаа өгөх	2025	-	Гамшгаас хамгаалах тухай: Зүйл 10-1.1; Зүйл8-1; Зүйл 13-2.5; Зүйл 34-1; Зүйл 34- 2
3	Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал алдагдах, дэд бүтцийн байгууламж болон уурхайн карьер, туунаах нуур сэтрэх, үер ус буух ажилчдын гэмтэл бэртэл үүсэх	Уурхайн ажлыг түр зогсоох, их үер усыг зайлуулах суваг шуудуу татах, үерийн хамгаалалт хийх, ажилчдад аюулгүй байдлын зааварчилгаа өгөх.			
Ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл					
1	Уурхайн тоног төхөөрөмж саатах, эвдрэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Сургалтын арга хэмжээ жил 2 удаа	0.5	
2	Зам маршрут өөрчилж явснаас үүдэн осол гарах санамсаргүй хоорондоо мөргөлдөх	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулж байх, техник хэрэгсэлд яаралтай үед ашиглах хэрэгсэл, эмийн сан тогтмол байлгах			
Нэг жилийн зардал мян.төг				1.5	

4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө		Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Ил задгай хог хаягдал үүсэж зөв зохицуулаагүйг ээс үүдэн хөрс, агаар, усны бохирдол бий болж дам нөлөө үүсэж мал амьтанд сөргөөр нөлөөлөх, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгах	Дахин ашиглагдах (шил, лааз, хуванцар, төмөр, мод, цаас) Даланжаргалан сумын түүхий эд авах цэгт нийлүүлэх – төслийн талбайгаас 15 км	Улирал бүр тээвэрлэн нийлүүлнэ	Хадгалах - сараалжин хашаа - 200.0 Тээвэрлэлт -50	250.0	“Хог хаягдлын тухай” хууль 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 40 дүгээр зүйл MNS 5924:2008 - Нүхэн жорлон, угаадасны нүх”
		Ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын цэгт нийлүүлэх (тээвэрлэх)	Уурхайд ажиллах 70 хүн өдөрт 0.5 кг хатуу хог хаягдал үүсгэнэ гэвэл 340 хоногт 11.9 тн хаягдлыг хог хаягдал тээвэрлэх эрх бүхий байгууллатай хамтран ажиллаж хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд тухай бүр	Улирал бүр	-	-	
	Аюултай	Шатах тослох материалын хаягдал зориулалтын саванд цуглуулж, хадгалах	Шатах тослох материалын үлдэгдлийг зориулалтын саванд цуглуулж хадгалан Төв аймгийн Сэргэлэн суманд байрлах “Хай Би Ойл” ХХК-д нийлүүлэх. Төслийн талбайгаас 250 км	Жилд 1-2 удаа	Хадгалах сав -300.0 Тээвэрлэлт – 250.0	550.0	
		Техникийн хог хаягдлыг хадгалах цэг байгуулах, эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх	Машин механизм, тэдгээрийг задлах, засварлах үйл ажиллагаанаас үүсэх тосны шүүр, агаар шүүгч, тэсрэмтгий шинж чанартай эд ангийн хаягдал, тоормосны жийргэвч, тоормосны шингэн болон батареи, аккумулятор зэрэг хаягдлыг эрх бүхий байгууллагад нийлүүлэх	Жилд 1 удаа	Хадгалах- тусгай зориулалтын битүүмжилсэн сав -100*3=300.0 Тээвэрлэлт- УБ- 300.0	600.0	
		Ажилчдад сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны явцад хог хаягдлын менежментийг эзэмшүүлэх	Жилд 1 удаа	-	-	
	Нийт					1400.0	

4.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал мян.төг	Зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР					
Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос PM _{2.5} , PM ₁₀ Тоосны уналт Бохирдлын цэгэн эх үүсвэр: SO _x , NO _x	1. Дотоод тээврийн замын дагууд салхин дор 2. Автозогсоол дахь машин техникээс	• Жилд 2 удаа 5,11 • Уурхайн дотоод зам талбайн тоосжилтийн байдалд өдөр бүр хэмжилт хийх, ажиглалт явуулж бүртгэл хөтлөх, зам талбайн тоос дарах ажилд хяналт тавих	шинжилгээний зардал 100.0*2*2	400.0	Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага: MNS 4585:2007 MNS:4048-88. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга. MNS 3384-82. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4585-98. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 12.055-91. Ажлын байрны агаар дахь тоосны хэмжээг тодорхойлох Дэлхийн банк. Төрөл бүрийн ажлын орчин дахь дуу шуугианы хязгаарлалтууд, 2007.04.30
Орчны дуу чимээ	-Уурхайн хилээс 2-оос доошгүй км зайд хэмжилт хийх -Дуу шуугиан ихтэй ажлын байруудад	Дотоод тээвэрлэлт болон бусад шуугианы эх үүсвэр дээр, стандартаас давсан тохиолдолд бууруулах арга хэмжээ авах	Дуу шуугианы хэмжилтийн багаж	154.0	
Замын арьчилгааг тогтмол хийх	Тээвэрлэлтийн 26.5 км замд засвар үйлчилгээ тогтмол хийх	Тээвэрлэлт хийхийн өмнө болон дараа хонхор гүдгэрийг засах, сул хэсгийг нягтруулах	Үйл ажиллагааны зардлаар		
2. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС					
Усны ерөнхий химийн шинжилгээ, pH, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO ₃),ууссан хүчилтөрөгч, BXX, XXX, Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ -ны агууламж, амт, үнэр, өнгө.	Уурхайн усны эх үүсвэр болон ойролцоох уст цэгээс (булаг)	жилд 2 удаа 5, 8 сард*2 байршилд	Усны ерөнхий химийн шинжилгээ 46.0	184.0	Усны тухай хууль 2012.05.17 Ундны усны чанарын стандарт MNS 900:2018
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ					

Шимт хөрсний хадгалалт, шимт хөрсний овоолгын өндөр, налуу, ургамалжилт	Шимт хөрсний овоолго	Жилд 2 удаа (5,8 сард)	Шимт хөрсний овоолго хамгаалах зардалд тусгагдсан		“Ариун цэврийн тухай” хууль: 7-р зүйл: 7.4, 7.5 Дээжлэлт хийхдээ MNS:3297:1991 MNS 3473:1983 MNS 4288:1995 MNS 5850:2008
Хөрсний химийн шинж чанар, механик бүрэлдэхүүн, хүнд металл, эрүүл ахуйн шинжилгээ хийлгэх	1.Уурхайн талбай, 2.зам дагуу, 3. хог хаягдлын цэгийн ойролцоо 4. техникийн засвар үйлчилгээний газрын ойролцоо 5. нөхөн сэргээлт хийсэн талбай	Жилд 2 удаа (5,8 сард)*4 байршилд	Химийн шинжилгээ - 20.0 Хүнд металл 30.0< Эрүүл ахуй 20.0	300.0	
4. УРГАМЛАН НӨМРӨГ					
Ургамлын зүйл, бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүн, үнэмлэхүй болон дундаж өндөр см, ургац ц/га	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар, талбайд	Төсөл хэрэгжих хугацаанд жилд нэг удаа (ҮП/20-ноос ҮП/20-ны хооронд буюу ургамлын масс цэцэглэлтийн үед)	Биологийн нөхөн сэргээлтийн зардал, хяналт мониторингийн зардалд тусгагдсан	Ургамлын хээрийн судалгааны геоботаникийн бичиглэл болон тэмдэглэл	
Ургамлан нөмрөг үүсэх төлөвшлийг хянах				Ургамлын хээрийн судалгааны геоботаникийн бичиглэл болон тэмдэглэл	
Нэг жилийн орчны хяналт шинжилгээний зардал, мян.төг			1 038.0		

4.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгаль орчныг хамгаалах тухай хуулын 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд хийлгэх	-	-	-	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Газрын төлөв байдал, чанарын хянан хянан байталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тусгай зөвшөөрлийн талбайд	4.0	5 жил тутамд	Газрын тухай хуулийн 58.5
Нийт		4.0		

4.10 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцү үлэх байгууллага	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
“Хүдрэнт” ХХК	БОМТ-ний үр дүнг танилцуулах	Уурхайн үйл ажиллагаа байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа нөлөөлөл болон сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлсэн, хяналт мониторингийн явцыг танилцуулна	Оны сүүлээр буюу 11 сард жилд 1 удаа тайлагнана	Цаашид уурхайн үйл ажиллагааг орон нутгийн иргэдтэй хамтран байгаль орчинд ээлтэйгээр хэрхэн хэрэгжүүлж болох талаар санал авна	Багийн иргэдийн нийтийн хурлын байр
Оролцогч сонирхогч талуудад БОМТ –г танилцуулах ажлын зардал (мян.төг)					
БОМТ –ний хэрэгжилтийн талаарх танилцуулга бэлтгэх					150.0
Оролцогчдын үдийн цай					500.0
зардал					650.0

2025 оны БОМТ –г хэрэгжүүлэхэд нийт 13 178 мян.төг зардал гарна. Үүнд:

- Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ – 1500 мян.төг
- Техникийн нөхөн сэргээлтийн зардал – 1590 мян.төг
- Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ – 1500 мян.төг
- Осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийн төлөвлөгөө- 1500 мян.төг
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө – 1400 мян.төг
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт – 1038 мян.төг
- БОТМ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө – 4000 мян.төг
- БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцэх – 650 мян.төг